



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 01/17


Улаанбаатар хот

Байгууллагын архивын дүрэм
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Архивын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дахь заалт, Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивт баримт хүлээн авах, шилжүүлэх журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын архивын ажлын дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Байгууллагын архивын ажлын дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулахыг байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгчид үүрэг болгосугай.
3. Байгууллагын архивын ажлын дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэн дүрмийн дагуу архивын баримтыг хүлээлгэн өгөхийг хэлтэс албадын, дарга, албан хаагчдад үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2015 оны А/64 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

1150500033